

# ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРААС 2019 ОНЫ 04 ДҮГЭЭР САРД ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН


2019 оны 05 дугаар сарын 02

Улаанбаатар хот

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гадаадын иргэн, харьяатын газар нь Төрийн албаны тухай хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Харьяатын тухай хууль болон холбогдох дүрэм, журам, зааврыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон гадаадын болон өөрийн орны иргэдэд түргэн шуурхай, чирэгдэлгүй үйлчлэхэд анхаарч 2019 оны 04 дүгээр сард дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

## НЭГ. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

### 1.1. Виз, зөвшөөрөл, харьяатын чиглэлээр:



Тайлангийн хугацаанд Монгол Улсад оршин суух үнэмлэх 2897 ширхгийг шинээр хэвлэн, 233 ширхэг үнэмлэхийн хүчинтэй хугацааг сунгаж, 17 ширхэг үнэмлэхэд хаягийн хөдөлгөөний бичилт хийлээ. Цагаач, гэр бүлийн шалтгаанаар оршин суугч гадаадын гурван иргэнд хувийн хэрэг шинээр нээж, 166 иргэний хувийн хэрэгт баяжилт хийн нийт 517 иргэний мэдээллийг цахим архивт оруулсан байна. Мөн гадаадын зургаан иргэнд регистрийн дугаар олгож, харьяалалгүй нэг хүнд зорчих үнэмлэх олгосон. Үйлчилгээний танхимд 2601 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг хүлээн авчээ. Визийн зөвшөөрөл, хувийн урилга олгох үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх програм хангамжийн хүрээнд найман иргэн, аж ахуйн нэгж, байгууллага бүртгүүлж, зургаан аж ахуйн нэгж, байгууллагын долоон гадаадын иргэний визийн зөвшөөрлийг шийдвэрлэлээ. Нийт 3106 иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгснөөс 1800-1882 дугаарын утсаар 2181, биечлэн 616 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа.

Үндэсний хөгжлийн газрын дэргэдэх хөрөнгө оруулагчдад төрийн үйлчилгээ үзүүлэх нэг цэгийн үйлчилгээний төвд тус байгууллагын хоёр мэргэжилтэн ажиллаж 164 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч, гадаадын 60 иргэнд визийн зөвшөөрөл, 54 иргэнд

оршин суух зөвшөөрөл олгож, 171 иргэний оршин суух зөвшөөрлийн хугацааг сунган, 20 иргэний ангиллыг сольж, долоон иргэнд бүртгэл, долоон иргэнд хасалт хийсэн байна. Мөн хөрөнгө оруулагчаар оршин суух зөвшөөрөлтэй 111 иргэнд зохих ангиллын виз олголоо.

2019 оны 04 дүгээр сарын дээрх тоон үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад визийн зөвшөөрөл олголт 9.9 хувиар, виз олголт 3.9 хувиар, хувийн урилга олголт 47.4 хувиар, оршин суух зөвшөөрөл олголт 4.4 хувиар, оршин суух зөвшөөрлийн хасалт 94.0 хувиар, түр ирэгчийн бүртгэл 7.2 хувиар, түр ирэгчийн хасалт 7.1 хувиар, визийн сунгалт 45.9 хувиар тус тус өссөн, харин оршин суух зөвшөөрөл сунгалт 5.3 хувиар буурсан байна.

Иргэний харьяалал, хүүхэд үрчлэлт, олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын чиглэлээр:

Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргасан гурван иргэний хүсэлтийг шинээр хүлээн авсан ба хуульд заасан шалгуурыг хангаагүй нэг иргэний хүсэлтийг буцаасан байна.

Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргасан гурван иргэний баримт бичгийг хянан холбогдох санал авахаар Улсын бүртгэлийн ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газарт хүргүүлээ.

Мөн Монгол Улсын харьяатаас гарч гадаадын таван улсын харьяат болох хүсэлт гаргасан 15 иргэний хүсэлтийг шинээр хүлээн авсан.

Монгол Улсын харьяатаас гарч гадаадын бусад улсын харьяат болох хүсэлт гаргасан 45 иргэний баримт бичгийг хянан холбогдох санал авахаар Улсын бүртгэлийн ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газарт, 72 иргэний хүсэлтэд холбогдох байгууллагаас санал авч дүгнэлт гарган Ерөнхий сайдад танилцуулахаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт, 17 иргэний хүсэлтийг Ерөнхий сайдад танилцуулсны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн барьсан байна.

Иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох хүсэлт гаргасан харьяалалгүй найман хүний хүсэлтэд холбогдох байгууллагаас санал авч дүгнэлт гарган Ерөнхий сайдад танилцуулахаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.

Мөн хоёрдмол харьяалал үүсгэсэн 66 иргэнийг бүртгэж мэдээллийн санд оруулсан ба нийт 3131 иргэн бүртгэлтэй байна.



Тайлант хугацаанд Мэргэжлийн зөвлөлийн хурлаар 25 төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын асуудлыг хэлэлцүүлэн хоёр байгууллагад шинээр үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгон, 21 байгууллагын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацааг сунган, хоёр байгууллагын үйл ажиллагаа эрхлэн зөвшөөрлийг түр түдгэлзүүлсэн байна. Түүнчлэн дээрх хугацаанд үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацааг сунгуулах хүсэлт гаргасан 12, татан буулгах хүсэлт гаргасан нэг, шинээр үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүссэн нэг олон улсын

болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын хүсэлтийг хүлээн авсан. 2019 оны 04 дүгээр сарын байдлаар тус байгууллагад бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж буй 97 төрийн бус байгууллага байна.

Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэн авах хүсэлт гаргасан хоёр улсын хоёр гэр бүлийн хүсэлтийг шинээр хүлээн авч холбогдох ажиллагааг эхлүүллээ. Гадаад улсын гэр бүлд үрчлүүлсэн хоёр хүүхдийн үрчлэлтийн дараах тайланг хүлээн авч, мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн.

#### 1.2. Хяналт шалгалт, албадан гаргах ажиллагааны чиглэлээр:

Тайлангийн хугацаанд Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн холбогдох заалтыг үндэслэн зургаан улсын 35 иргэнийг байгууллагын даргын 14 удаагийн тушаалаар тус улсаас албадан гаргасан ба мэдээллийг холбогдох газруудад албан бичгээр хүргүүлэх ажлыг зохион байгуулж ажиллалаа. Мөн байгууллагын даргын тушаалаар Монгол Улсаас албадан гаргасан хоёр улсын зургаан гадаадын иргэний Монгол Улсаас албадан гаргасан тушаалыг хугацаанаас өмнө цуцалсан.


Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасан үндэслэлээр байгууллагын даргын дөрвөн удаагийн тушаалаар гурван улсын дөрвөн иргэнийг Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлж, хоёр удаагийн тушаалаар нэг улсын хоёр иргэний хилээр нэвтрэх эрхийг сэргээн ажиллалаа.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйл, Засгийн газрын 2018 оны 145 дугаар тогтоолд заасны дагуу 236 гадаадын иргэнийг орох чиглэлд хил нэвтрүүлэлгүй буцаажээ.

Монгол Улсаас хилийн чанадад суугаа Элчин сайдын яам, консулын газар, өргөмжит консулаас визийн хүчинтэй хугацаа, нэр, огноо буруу, визийн зориулалт бичигдээгүй зэрэг 10 иргэнд олгогдсон визийг тухай бүр хуулбарлан авч, Засгийн газрын 2018 оны 145 дугаар тогтоолын дагуу визийг дахин олгон хил нэвтрүүлсэн болно.

Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүгчийн хоёр захирамжаар гадаадын хоёр улсын хоёр иргэнийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Баривчлах төвийн дэргэдэх гадаадын иргэнийг саатуулах байранд саатуулсан.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд заасан үндэслэлээр нэг иргэнд гарах сануулга өгсөн байна.



Тайлангийн хугацаанд хоёр удаагийн төлөвлөгөөт, 29 удаагийн төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулж, нийт 51 аж ахуйн нэгж, байгууллага, 169 гадаадын иргэнийг хамруулсан ба 113 гадаадын иргэн, 62 аж ахуйн нэгж, байгууллага /113 гадаадын иргэн/, гурван уригч иргэн /гурван гадаадын иргэн/-д Зөрчлийн тухай хуулийн дагуу шийтгэл оногдуулж, 93,380,000 /ерэн гурван сая гурван зуун наян мянга/ төгрөгийг улсын төсөвт төвлөрүүллээ.

2019 оны 04 дүгээр сарын дээрх тоон үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад зөрчил гаргасан гадаадын иргэн 0.9 хувиар, зөрчил гаргасан уригч хуулийн этгээд 31.9 хувиар, зөрчил гаргасан уригч иргэн 2 дахин, гарахыг түдгэлзүүлсэн гадаадын иргэн 3 дахин тус тус өссөн, харин албадан гаргагдсан гадаадын иргэн 44.4 хувиар буурсан байна.

## ХОЁР. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

### 2.1. Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, дотоод ажлын чиглэлээр:

Бодлогын баримт бичигт тусгагдсан тус байгууллагын үйл ажиллагаанд холбогдох 2007-2018 оны хэрэгжиж дууссан болон хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийг нэгтгэн Хууль зүй, дотоод хэргийн сайдад, Засгийн газрын 2016 оны 233 дугаар тогтоолоор баталсан “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт, Хууль зүй, дотоод хэргийн сайдын зөвлөлийн хуралдаанаас өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргад, байгууллагын 2019 оны 03 дугаар сарын үйл ажиллагааны тоон мэдээг инфографик хэлбэрээр гарган Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын даргад, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 05 дугаар зарлигаар баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журам”-ын дагуу тус байгууллагад холбогдох хэсгийн тайлан, байгууллагын 2019 оны 03 дугаар сарын үйл ажиллагааны тайланг нэгтгэн Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт, Засгийн газрын 2016 оны 204 дүгээр тогтоолоор баталсан “Нэгдсэн Үндэстний Байгууллагын хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг 2016-2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөө”-ний тус байгууллагад холбогдох арга хэмжээний хэрэгжилтийг нэгтгэн Хууль зүй, дотоод хэргийн яамны Гэрээ, эрх зүй, хамтын ажиллагааны газрын даргад тус тус хүргүүлж ажиллалаа.

Байгууллагын “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2019 оны төлөвлөгөө”-ний нэгдүгээр улирлын биелэлтийг Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албанд хүргүүлсэн.

Засгийн газрын 2019 оны “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил” болгох тухай 23 дугаар тогтоолыг салбарын хэмжээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны А/14 дүгээр тушаалаар баталсантай холбогдуулан тус байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэх ажлын нарийвчилсан төлөвлөгөөг нэгтгэн боловсруулж, байгууллагын даргын 2019 оны А/136 дугаар тушаалаар батлуулан, дотоод сүлжээгээр нийт албан хаагчдад хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Байгууллагын даргын 2019 оны А/121 дүгээр тушаалаар “Эмнэлгийн анхны тусламж үзүүлэх журам”, “Яаралтай болон анхны тусламжийн эм тарианы жагсаалт, эмнэлгийн хэрэгслийн жагсаалт, эмчийн өрөөнд байх эд зүйлсийн жагсаалт”-ыг баталлаа.

2019 онд явагдах архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтын улсын үзлэгт бэлтгэх, байгууллагын дотоод ажлын зохион байгуулалт, ажилтнуудын баримт бичигтэй ажиллах чадамжийг дээшлүүлэх, харилцан туршлага солилцох зорилгоор байгууллагын даргын 2019 оны Б/95 дугаар тушаалын дагуу “Захиргааны албан хаагчдын сургалт”-ыг зохион байгуулж, сургалтад төв болон орон нутаг дахь газрын 36 албан хаагч хамрагдлаа.

Мөн байгууллагын даргын 2019 оны А/112 дугаар тушаалаар батлагдсан “Албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн батлах тухай” ажлын хэсэг гурван удаа хуралдаж, албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг төрийн албаны тухай хуульд нийцүүлэн боловсруулж байна.

Албан хаагчдын мэдээллийн цагаар Шинэ Монгол сургуулийн зөвлөх багш Н.Отгонтуяа “Гэр бүлийн харилцаа” сэдвээр, байгууллагын сүлжээний ерөнхий инженер Энэтхэг Улсын засгийн газрын тэтгэлэгт ИТЕС сургалтад хамрагдсан тухай, мөн сүлжээний инженер Тайвань Улсын Тайпэй хотын /National Taiwan Normal University Mandarin Training Center/-т Хятад хэлний бэлтгэлд хамрагдсан тухай мэдээллийг төвийн 71 албан хаагчдад, “Хан голомт групп”-ийн захирал, Монголын илтгэгчдийн холбооны ерөнхийлөгч Ц.Азбаяр “Төрийн албан хаагчийн өрсөлдөх чадвар, хандлага, зан үйл” сэдвээр төвийн 61, орон нутагт онлайн хэлбэрээр 45 албан хаагчдад, Хан-Уул дүүргийн улаан загалмайн хорооны арга зүйч Б.Оюунчимэг “Анхны тусламжийн ач холбогдол, зарчим, зүрх уушгины сэхээн амьдруулалт, ухаангүй хүнд үзүүлэх анхны тусламж, ухаангүй амьсгалтай хүнд үзүүлэх анхны тусламж, цус алдалт хугарлын үед үзүүлэх анхны тусламж” сэдвүүдийн хүрээнд төвийн 50, орон нутагт онлайн хэлбэрээр 54 албан хаагчдад мэдээлэл, сургалт тус тус орсон.

Бүгд Найрамдах Солонгос Улсын олон улсын хамтын ажиллагааны байгууллага “KOICA”-ын төслөөр хэрэгжиж буй “ORACLE DB” өгөгдлийн сангийн сертификаттай сургалтад Мэдээллийн технологийн хэлтсийн гурван албан хаагч хамрагдаж байна.

Монголын үндэсний олон нийтийн телевизээр “Бүх нийтийн эрх зүйн боловсрол” шууд нэвтрүүлэгт “Гадаадын иргэдийн виз, визийн зөвшөөрөл, хяналт шалгалт” сэдвээр хяналтын улсын ахлах байцаагч, виз, зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн нар оролцож байгууллагын үйл ажиллагааг сурталчилсан бөгөөд нэвтрүүлгийг байгууллагын цахим хуудаст байршуулан олон нийтэд хүргэлээ.

Түүнчлэн “Eagle” телевизийн “Зочны цаг” шууд нэвтрүүлэгт виз, зөвшөөрөл, харьяатын газрын мэргэжилтэн, мэдээлэл лавлагааны мэргэжилтэн нар оролцож, виз, зөвшөөрлийн цахим үйлчилгээтэй холбоотой мэдээллийг олон нийтэд хүргэв.

Байгууллагын даргын 2018 оны А/107 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан “Гадаадын иргэн, харьяатын газрын газар, хэлтсээс архивт баримт хүлээн авах хуваарь”-ийн дагуу тайлангийн хугацаанд нийт 108 хадгаламжийн нэгжийг бүртгэлийн дагуу архивт хүлээн авч, сан хөмрөгийг нөхөн бүрдүүлсэн байна.

Тус байгууллагын архивын дэргэдэх “Баримт бичиг нягтлан шалгах комисс”-ын бүрэлдэхүүнийг байгууллагын даргын 2019 оны А/63 дугаар тушаалаар шинэчлэн баталж, дараах асуудлыг хэлэлцлээ. Үүнд:

- 2019 онд зохион байгуулалтын нэгжид үүсэж бий болох баримтын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг хэлэлцүүлж комиссын гишүүдийн олонхын саналаар баталсан;

- Байгууллагын архивын байнга хадгалах 2003-2017 оны 1134 хадгаламжийн нэгжийн данс;

- 2001-2017 оны 70 жил хадгалах 203 хадгаламжийн нэгжийн бүртгэл;
- 2008-2017 оны 10 жил хадгалах нийт 4705 хадгаламжийн нэгжийн бүртгэл;
- 2001-2016 оны 10568 устгах хэрэгт үйлдсэн актыг тус тус хэлэлцүүлж батлуулж данс бүртгэлийг Үндэсний төв архивын дэргэдэх Баримт бичиг нягтлан шалгах арга зүйн комисст албан бичгээр хүргүүлээ.

Төв болон орон нутаг дахь газарт нийт 42 өргөдөл ирснийг хүлээн авч, бүртгэлжүүлэн харьяалах газар, хэлтэст нь шилжүүлснээс 30 өргөдөл шийдвэрлэгдэж, 12 өргөдөл хуульд заасан хугацааны хүрээнд шийдвэрлэлтийн шатандаа байгаа ба хугацаа хэтэрсэн өргөдөл байхгүй.

## 2.2. Хууль, эрх зүй, гадаад харилцааны чиглэлээр:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгах санал, “Шинжилгээнд зориулан тусгайлан авсан хэв, загвар, дээжийн хадгалалт, тээвэрлэлтийн горим батлах тухай” Засгийн газрын тогтоолын төсөлд холбогдох саналыг боловсруулан Хууль зүй, дотоод хэргийн сайдад, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн төсөлд тусгах саналыг боловсруулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад тус тус хүргүүлэв.

Засгийн газрын 2018 оны “Хилийн хяналт шалгалтыг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” 306 дугаар тогтоолын хүрээнд “Зорчигчийн урьдчилсан мэдээллийг системийг нэвтрүүлэх тухай” гэрээний төслийг боловсруулан нэр бүхий 13 байгууллагад санал авахаар хүргүүлэв.

Шинээр томилогдохоор нэр дэвшсэн хоёр, дэвшин томилогдохоор нэр дэвшсэн нэг, шилжин томилогдохоор нэр дэвшсэн хоёр албан тушаалтны хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газарт хянуулахаар хүргүүлж, шинээр томилогдсон зургаан албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд хүлээн авч баталгаажуулав.

Авлигатай тэмцэх газраас 2019 оны 03 дугаар сарын 22-ноос 28-ны өдрүүдэд тус байгууллагад төлөвлөгөөт хяналт шалгалтыг зохион байгуулсан бөгөөд шалгалтын мөрөөр ирүүлсэн зөвлөмжийн дагуу “Гадаадын иргэн, харьяатын газраас Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр 2019 онд авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-г баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Байгууллагын дарга Олон Улсын Энэрлийн Байгууллагын Азийн бүсийн удирдагч ноён Петер Флечер Мейрстай, Эрх зүй, гадаад харилцааны хэлтсийн дарга, Хойд бүс дэх газрын дарга, Дорноговь аймаг дахь газрын дарга тэргүүтэй төлөөлөгчид Бүгд Найрамдах Турк Улсын “ТИКА” байгууллагын Улаанбаатар дахь Хөтөлбөрийн ерөнхий зохицуулагч ноён Емрах Устамортэй хамтын ажиллагааны талаар тус тус уулзалт зохион байгуулав.

Монгол Улс, Бүгд Найрамдах Турк Улсын цагаачлал, шилжилт хөдөлгөөний ижил чиг үүргийн байгууллагын хооронд байгуулсан “Хамтын ажиллагааны тухай хамтарсан мэдэгдэл”-ийн хүрээнд байгууллагын дарга тэргүүтэй төлөөлөл Бүгд Найрамдах Турк Улсын Шилжилт хөдөлгөөний ерөнхий газарт, Анкара хотноо ажлын айлчлал хийлээ. Айлчлалын хүрээнд төлөөлөгчид Шилжилт хөдөлгөөний ерөнхий газарт дарга Абдуллах Аязтай удирдлагын анхны уулзалтаа хийж хоёр талын хамтын ажиллагааны талаар хэлэлцлээ.

### 2.3. Мэдээллийн технологийн чиглэлээр:

Тайлант хугацаанд “E-Visa” системийн туршилт, тестийг хийж дууссан бөгөөд туршилтын явцад илэрсэн алдаа, нэмэлт саналуудыг хүлээн авч засвар, шинэчлэлтүүдийг хийснээр системийг цахим хуудсанд байршууллаа.

Байгууллагын дотоод болон интернет сүлжээнд ашиглагдаж буй нийт компьютерийн “MAC” бүртгэлийн судалгааг шинэчлэн, тохиргоог хийж сүлжээний аюулгүй байдлыг нэмэгдүүлж ажилласан.

### 2.4. Хяналт-шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн чиглэлээр:

Байгууллагын үндсэн үйл ажиллагааны 2019 оны 03 дугаар сарын болон нэгдүгээр улирлын мэдээг Үндэсний аюулгүй байдлын ажлын алба, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Ерөнхий сайдын ажлын албанд, статистик мэдээг Хууль зүй, дотоод хэргийн яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт тус тус хүргүүлсэн.

Тус байгууллагын 90 ажлын байрны тодорхойлолтод давхардал, хийдлийг арилгах зорилгоор албан хаагчдаас анкетын болон ярилцлагын арга, нотлох баримтад тулгуурлан шинжилгээ хийж гүйцэтгэлээ.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2019 оны нэгдүгээр улирлын байдлаар хяналт тавин 258 мэдээллийн иж бүрэн, үнэн зөв, ач холбогдолтой хугацаанд байршуулсныг нягталж үзэхэд хэрэгжилт 98.4 хувьтай байна.

Төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалд тавигдах тусгай шаардлагыг батлах тухай Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан шаардлага болон байгууллагын даргын 2018 оны А/441 дүгээр тушаалаар баталсан шаардлагыг албан хаагч нэг бүрээр холбогдох хууль тогтоомжид заасны нотлох баримтад тулгуурлан үзлээ.

Мөн байгууллагын даргын 2019 оны 01-09/08 дугаар удирдамжийн дагуу хүний нөөцийн үйл ажиллагааг явуулахад холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг хэрхэн дагаж мөрдөж байгаа талаар хяналт тавих, зөрчил дутагдлыг арилгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал дүгнэлт гаргах зорилгоор дотоод шалгалт явуулав.

Тайлангийн хугацаанд Монгол Улсын хилээр 133 орны 76437 гадаадын иргэн хил нэвтэрснээс түүвэрчилж 325 гадаадын иргэдийн хил нэвтрэлтэд хяналт тавихад Монгол Улсад оршин суух зөвшөөрөлтэй иргэний гарах-орох визгүй хоёр, “ISM” мэдээллийн санд бүртгээгүй нэг зөрчил илэрснийг Хил хамгаалах байгууллагад мэдээлсэн. Мөн 2019 оны 02 дугаар сард хилийн шалган нэвтрүүлэх чиг үүргийг хэрэгжүүлж буй албан хаагчид виз, бүртгэлийн зөрчил бүхий долоон гадаадын иргэнийг тус байгууллагад шилжүүлэлгүйгээр улсын хил нэвтрүүлсэн тухай холбогдох мэдээллийг Хил хамгаалах ерөнхий газрын Боомтын аюулгүй байдал, шалган нэвтрүүлэх газарт албан бичгээр хүргүүлсэн.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 22 дугаар захирамжийн хүрээнд байгууллагын даргын 2019 оны А/67 дугаар тушаалаар “Торгоны зам” авто ралли уралдаанд оролцогч гадаадын иргэний хил нэвтрэлт, виз, зөвшөөрлийн бэлтгэл ажлыг хангах ажлын хэсэг байгуулагдсаны дагуу ажлын хэсгийн хурлыг зохион байгуулж, авто ралли уралдаанд оролцогч гадаадын иргэний хил нэвтрэлт, виз, зөвшөөрөл олгох үйл ажиллагаа явуулах бэлтгэл ажил хангах чиглэлээр холбогдох үүрэг, чиглэлийг өгч ажиллалаа.

Зорчигчийн урьдчилсан мэдээллийн дэвшилтэт системийг Бүгд Найрамдах Хятад Ард Улсад “АРИНК” /Rockwell Collins/ компанитай хамтран хэрэгжүүлсэн “Owinfo” компанийн болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Таншан хотын олон улсын хил дамнасан цахим худалдааны платформын нээлтийн үйл ажиллагаатай танилцан туршлага судлав.

#### 2.5. Санхүү, хөрөнгө оруулалт, хангамжийн чиглэлээр:

Гадаадын иргэн, харьяатын газрын даргын багцад Монгол Улсын Төсвийн тухай хуулийн дагуу 2019 онд 6.27 тэрбум төгрөг батлагдсан бөгөөд өссөн дүнгээр 04 дүгээр сард 2.09 тэрбум төгрөгийн санхүүжилт олгогдсоноос 1.7 тэрбум төгрөгийг зохих дүрэм, журмын дагуу анхан шатны баримтыг үндэслэн зарцуулсан болно.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Засгийн газрын 2003 оны 172 дугаар тогтоолын дагуу 2019 оны 04 дүгээр сарын байдлаар 1 тэрбум 280 сая төгрөгийн тэмдэгтийн хураамжийн орлого, 331.5 сая төгрөгийн хүү торгуулийн орлого, 49,0 сая төгрөгийн визийн хуудасны орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлээ.

Байгууллагын төв байрны шилэн фасад засварын тендер 2019 оны 03 дүгээр сарын 28-ны өдөр нээгдсэн ч тендерт аж, ахуйн нэгжүүд материал ирүүлээгүй тул Төрийн болон, орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.4-т заасны дагуу “Шилэн бадрангуй” ХХК-тай 14.8 сая төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулан ажиллаж байна

#### 2.6. Хилийн боомт, орон нутгийн чиглэлээр:

Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ой, Монгол Улсын Гадаадын иргэн, харьяатын газрын Дорноговь аймаг дахь газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Эрээн хотын Дотоодыг хамгаалах товчоо хоорондын хамтран ажиллах протоколд гарын үсэг үзэглэсний нэг жилийн ойг тохиолдуулан хоёр талын албан хаагчдын спортын нөхөрсөг тэмцээн Эрээн хотод зохион байгуулагдсан.

Дорноговь аймгийн “Хууль сахиулах чиг үүргийн байгууллагын Төрийн албан хаагчдын нэгдсэн зөвлөгөөн” Сайншанд суманд зохион байгуулагдаж Дорноговь аймаг дахь газрын таван албан хаагч, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Хууль сахиулахын их сургууль, Хууль зүйн үндэсний хүрээлэн болон Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан “ХАНДЛАГА-ӨӨРЧЛӨЛТ” сэдэвт төрийн албан хаагчдын нэгдсэн зөвлөгөөнд Дорнод аймаг дахь Зүүн бүс дэх газрын гурван албан хаагч тус тус хамрагдлаа.

Боршоо боомтод үйл ажиллагаа явуулж буй хил хяналтын байгууллагуудтай хамтран зохион байгуулсан “Нээлттэй хаалганы өдөрлөг”-т Ховд аймаг дахь Баруун бүс дэх газрын хоёр албан хаагч оролцож байгууллагын үндсэн чиг үүрэг, үйл ажиллагааны талаар мэдээлэл хийж, улсын хилээр зорчигч Оросын Холбооны Улсын 180 иргэнд холбогдох мэдээлэл бүхий гарын авлага тараан, байгууллагын үйл ажиллагааг сурталчилж ажилласан.